

АХМАД БАГШ МИНИЙ ҮГ

Х.Буджаав

Сурган хүмүүжүүлэх ухааны нэрт эрдэмтэн Г.Эрдэнэ-Очирын амьдралын түүхэн замнал, бүтээл туурвилын үнэ цэнийг үнэлж цэгнэж байгаад туйлын их баяртай байна. Хүүхэд залуучуудыг сургаж хүмүүжүүлэхэд, хөдөлмөрт сурахад ахмад хүмүүсийн үлгэрлэн манлайлах, хөдөлмөрийг хүндэтгэх үзэл, байгаль ертөнцийг танин мэдэх, өргөн хүрээтэй сэдвээр ардын сурган хүмүүжүүлэх зүйг шинжлэх ухааны үндэслэлээр нотолж чухал, чухал санааг сэдэж аргачлалыг заасан асуудлыг хөндөж тавьснаараа эрдэмтэн, мэргэд, багш, сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхийн анхаарлыг татсан бүтээл туурвисан гэж боддог юм.

Энэ учраас нэрт эрдэмтний бүтээл туурвилыг сэргээх ажлыг төрсөн нутаг, төрөлх сургуулиас нь эхэлье гэж бодож зарим хүмүүстэй санал солилцож явтал 2006 онд Г.Эрдэнэ-Очирын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг эрдэмтэн Б.Батсайхан, Н.Бэгз, До.Ванчигсүрэн нар ном болгоод гаргаж ирсэн нь ахмад багш миний сэтгэлийг сэргээж, шавийнхаа бүтээл туурвилыг ажил хэрэг болгож, цаашид үргэлжлүүлэх юм гэсэн хүслийг минь МУБИС-ийн, Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн мэргэд, хань ижил үр хүүхэд, анд найз, ангийн хамт олон дэмжсэнд гүнээ талархаж байна. Ийм нэрд гарсан эрдэмтэн болоход багаасаа яаж сурсныг та бүхэнд мэдээлье.

-1-р ангиас 10-р анги төгсгөлөө ойлгосон, ойлгоогүй үзсэн хичээл болгоноо цээжилж явсан, ойлгоогүй цээжилснээ бодож эргэцүүлж ойлгох эсвэл өөр номоос унших, бусдаас асууж мэдэхэд хялбар байдаг.

-УБДС-д ороод цээжлэх шаардлагагүй, уншсан сонссон болгон нь ой ухаандаа хадгалдаг болсон.

-Номыг маш хурдан уншдаг нь ойлгох тутам уншилтын хурд нэмэгддэг.

-Хурдан бичилтэн нь ойлголт, үзгээ зөв барилттай холбоотой гэж ярьдаг байлаа.

-Уран илтгэх нь гайхмаар сайхан, хүний сэтгэлийг хөгжимчин хүн хөгжмийг хөглөөд хөгжимдөхөд хүмүүсийн сэтгэл баясан татагддагийн адил сонсогчдын сэтгэл оюуныг соронзон мэт татан ухааруулаад өгдөг байлаа.

-Бүтэн амралтын өдөр ээлжийн амралтыг өнгөрүүлэхдээ үдээс өмнө уншиж судлах бичиж боловсруулах, гэр орондоо хийж бүтээхэд зориулаад, үдээс хойших цагаа гэр бүл, үр хүүхэд, чөлөөт амралтаар амрах хэвшил тогтсон. Энэ бүхнийг би хүлээн зөвшөөрч, хамтран ажиллаж байхдаа ч одоо ч ач зээ нартаа хэрэгжүүлэх гэж хичээж явдаг, зохих үр дүн гарсаар байна. Төрсөн нутгаасаа эхлэн ажилласан газар бүртээ сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны чиг хандлагад шинэ санаа бодол дэвшүүлэхээс гадна тохилог орчин бүрдүүлэх их ажил өрнүүлж байсан юм. Ийм үлгэр жишээч ухаалаг шавьтай байсандаа бахархдаг. Энэ бахархлаа ажил хэрэг болгохын тулд Дундговь аймгийн 1-р 10 жилийн зарим сурагчид, Дэрэнгийн 6-9-р ангийн сурагчид, багш нарт сурталчилж байсан миний хүсэл бодолд биелэх магадлалын эх тавигдлаа.